



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.8, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Онцгой байдлын ерөнхий газрын ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан зааврыг мөрдөж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ц.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



ГАРИУНБУЯН

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗААВАР

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Зорилго

1.1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үеийн ажиллагааны удирдлагыг зөв оновчтой, шуурхай хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангах, Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, зохион байгуулалтын нэгжүүдийн чиг үүргийг тодорхой болгох, мэдээ, мэдээлэл солилцох, харилцан ажиллагааг зохион байгуулахад зааврын зорилго оршино.

1.2. Хамрах хүрээ

1.2.1. Энэхүү зааврыг Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага дагаж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ мэдээллийг хүлээн авах, дамжуулах, удирдлага зохицуулалтаар хангах

2.1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлагаар түрүүлж очсон бүрэлдэхүүн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Шуурхай ажиллагаа зохион байгуулах журам” [1]-ын 2.4 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1.2. Гамшиг ослын голомтод хүрэлцэн очсон аврах ажиллагааны удирдагч нөхцөл байдал, гамшиг ослын цар хүрээг үнэлж, мэдээллийг Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид дамжуулна.

2.1.3. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нь ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл, нөхцөл байдал, цар хүрээ, хохирлоос хамаарч Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга, Тэргүүн дэд дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга гэсэн дарааллаар мэдээллийг дамжуулна.

- Шуурхай удирдлагын оператор нь Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн хэлтсийн дарга нар, чиглэл хариуцсан алба хаагчдад;

- Техникийн бэлэн байдал хариуцсан инженер нь бусад шаардлагатай зохион байгуулалтын нэгжийн дарга нарт мэдээллийг тус тус дамжуулна.

2.1.4. Зохион байгуулалтын нэгжүүд Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчаас “Яаралтай цуглар” дохио авсан даруй Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/314 дүгээр тушаалаар баталсан “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам” [2], Бэлэн байдлын удирдамж [3], Онцгой байдлын байгууллагын чиглэлийн төлөвлөгөө [4]-ний дагуу ажиллана.

2.1.5. Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн зэрэглэл тогтоох журам” [5]-ын 3.1-д заасныг үндэслэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын цар хүрээ, нэрвэгдсэн болон амь насаа алдсан хүний тоо, хамарсан нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарч ажиллагааны удирдлагын дарааллыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

- Орон нутаг, 1 аймаг, 1 дүүрэг, 2 хүртэлх объектийн хэмжээнд орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга,

- 3 хүртэл аймаг, дүүрэг, хэд хэдэн объект болон онц чухал объектын хэмжээнд Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга,

- Улсын хэмжээний буюу 2-оос дээш бүс, нийслэл, улсын онц чухал объектын хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга удирдлага, зохицуулалтаар тус тус хангана.

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас үрэгдэх, улсын онц чухал объект, дэд бүтцэд ноцтой эвдрэл гэмтэл үүсэх, нийгэм, эдийн засаг, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Засгийн газар, Улсын онцгой комиссоос холбогдох шийдвэр гаргана.

2.1.6. Гамшгийн зэрэглэлээс шалтгаалж шуурхай штаб байгуулан ажиллах тохиолдолд Улсын онцгой комиссын даргын 2025 оны 5 дугаар тушаалаар баталсан “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам” [6]-ын дагуу зохион байгуулагдан ажиллана.

2.1.7. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, Ажиллагааны удирдлага, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга нараас бусад нэгжийн дарга нар “Яаралтай цуглар” дохиогоор ажлын байранд ирж, хариуцсан чиглэлийн дагуу үүрэг гүйцэтгэх бөгөөд зөвхөн Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод очиж ажиллана.

2.1.8. Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын нэгжүүд, төв орон нутгийн онцгой байдлын байгууллагууд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” [7]-ийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

2.1.9. Гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд гамшиг ослын голомтод хөдөлгөөнт удирдлагын байрыг дэлгэн ажиллуулна.

2.1.10. Хөдөлгөөнт удирдлагын байрыг төхөөрөмжлөх үүргийг Холбоо, мэдээллийн технологи, Санхүү, ар тал, Ажиллагааны удирдлага, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжүүд хариуцна.

2.1.11. Хөдөлгөөнт удирдлагын байранд шаардагдах техник, тоног төхөөрөмж, хэрэгсэлийн жагсаалтыг хавсралтад заасны дагуу бүрдүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН УДИРДЛАГА, БҮТЦИЙН НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын дарга:

3.1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг ерөнхий /стратегий/ удирдлагаар хангаж, үүрэг, чиглэл өгч, холбогдох шийдвэр гаргана;

3.1.2. Улсын онцгой комисс, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг нөхцөл байдлын мэдээллээр хангаж, Монгол Улсын Шадар сайдад

үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шийдвэрлүүлэх асуудлын талаар танилцуулна;

3.1.3. Улсын онцгой комиссыг хуралдуулж, холбогдох шийдвэр гаргуулах, Гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн ангийн хүн, хүч хэрэгслийг ажиллагаанд татан оролцуулах саналыг Улсын онцгой комисст танилцуулж шийдвэрлүүлэх;

3.1.4. Төрийн цэргийн байгууллагын анги, салбарыг ажиллагаанд оролцуулах шийдвэрийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3-т заасны дагуу Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид танилцуулан шийдвэрлүүлэх;

3.1.5. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/410 дугаар тушаалаар баталсан “Эрэн хайх ажиллагаа ОББС 0001:2018” стандарт [8]-д заасны дагуу Үндэсний аврах бригад, 2 ба түүнээс дээш бүсийн хүч хэрэгслийг дайчлан гаргах;

3.1.6. Дайчлан гаргасан болон татан оролцуулсан хүч хэрэгслийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах талаар Ажиллагааны удирдлага, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга нарт үүрэг чиглэл өгнө.

3.1.7. Ажиллагааны удирдлага, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга нарын саналыг үндэслэн агаараас эрэн хайх, аврах, гал түймэр унтраах, гамшиг ослын бүсэд хүч хэрэгсэл хүргэх, нэрвэгдэгчийг татан авах ажиллагаанд нисдэг тэрэг ажиллуулах шийдвэр гаргана.

3.2. Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга:

3.2.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаар мэдээлэл авмагц нөхцөл байдлыг урьдчилсан байдлаар үнэлж, Онцгой байдлын ерөнхий газрын даргад үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шийдвэрлүүлэх асуудлын талаар танилцуулах;

3.2.2. Улсын онцгой комиссын шуурхай штабыг байгуулан ажиллуулах саналыг танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулах;

3.2.3. Улсын онцгой комиссын шуурхай штабыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

3.2.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлох хугацаанд чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.2.5. Холбогдох зохион байгуулалтын нэгжийн дарга нарт үүрэг чиглэл өгч, удирдлагаар хангах;

3.2.6. Хил залгаа хөрш орнуудтай гамшиг, осол, гал түймрээс хамгаалах, хил орчмын нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй гамшиг, осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх асуудлаар хамтран ажиллах;

3.2.7. Гамшгийн үеийн хэрэгжүүлж буй арга хэмжээний явцыг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3. Дэд дарга /Сургалт, эрсдэл, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан/:

3.3.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаар мэдээлэл авмагц ажлын байранд ирж хариуцсан зохион байгуулалтын нэгжийн бие бүрэлдэхүүнийг яаралтай цуглуулах, бэлэн байдлыг хангуулах, удирдлагаар хангаж ажиллах;

3.3.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, болзошгүй эрсдэлийг үнэлэх, шаардлагатай зөвлөмж боловсруулах;

3.3.3. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаар хэвлэл

мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, буруу ташаа мэдээлэл түгээхээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн цар хүрээ нийгэмд хэрхэн хүрч, үйлчилж байгаа талаар судалгаа, мониторинг хийх;

3.3.4. Онцгой байдлын ерөнхий газрын дарга (түүний эзгүйд тушаалаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан)-ын албан үүргийг түр орлох хугацаанд чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.3.5. Хөдөлгөөнт болон хөдөлгөөнт бус урьдчилан сэргийлэх, зарлан мэдээлэл хүргэх арга хэмжээг зохион байгуулна.

3.4. Дэд дарга /Санхүү, ар тал хангалт, улсын нөөц, холбоо хариуцсан/:

3.4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаар мэдээлэл авмагц ажлын байранд ирж хариуцсан зохион байгуулалтын нэгжийн бие бүрэлдэхүүнийг яаралтай цуглуулах, бэлэн байдлыг хангуулах, удирдлагаар хангаж ажиллах;

3.4.2. Ар тал, хангалт, логистикийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, улсын нөөцөөс бараа, материал гаргах Засгийн газрын тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулан батлуулах, удирдлагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллах;

3.4.3. Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж, хувцас хэрэглэлийг тогтоосон стандарт, норм нормативын дагуу хангалтыг зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхэд удирдлагад дэмжлэг үзүүлэх.

3.4.4. Онцгой байдлын ерөнхий газрын дарга (түүний эзгүйд тушаалаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан)-ын албан үүргийг түр орлох хугацаанд чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.5. Улсын онцгой комиссын ажлын алба

3.5.1. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Улсын онцгой комиссын ажиллах журам” [9]-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.5.2. Нөхцөл байдалд өгсөн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай яам, агентлагийн саналыг нэгтгэн Улсын онцгой комисст танилцуулах, Улсын онцгой комиссын хурал зохион байгуулах, шийдвэр гаргуулах;

3.5.3. Мэргэжлийн байгууллага, шинжээчдээр гамшгийн цагийн байдлын үнэлгээ хийлгэх;

3.5.4. Засгийн газраас олгосон бараа, материал болон олон улс, хүмүүнлэгийн тусламжийг гамшгийн голомтод хүргэх, түгээх үйл ажиллагаанд хяналт тавих;

3.5.5. Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

3.6. Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.6.1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс “Яаралтай цуглар” дохио хүргэсэн үед нэгжийн дарга нөхцөл байдлыг үнэлж голомтод очих эсвэл ажлын байран дээр ирэх талаар шийдвэр гаргаж, удирдлагад мэдэгдэнэ;

3.6.2. Нэгжийн бие бүрэлдэхүүнийг цуглуулж бэлэн байдлыг хангуулж, үүрэг чиглэл өгнө;

3.6.3. Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн зэрэглэл тогтоох журам” [10]-ын дагуу улбар шар, улаан түвшний гамшгийн үед ажиллагааг удирдлага, зохицуулалт, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.6.4. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон харилцан ажиллагааны төлөвлөгөөг тодотгох;

3.6.5. Нөхцөл байдлын мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийж, ажиллагааны хувилбаруудыг боловсруулах;

3.6.6. Тухайн чиглэлийн мэргэжилтэнг газар орон дээр нь томилон ажиллуулах;

3.6.7. Гамшиг ослын голомтод ажиллаж буй алба хаагч ослын удирдлагыг хэрэгжүүлнэ, хэрэв дээд шатны албан тушаалтан ослын удирдлагыг албан ёсоор шилжүүлж аваагүй тохиолдолд зөвхөн хэрэгжүүлэх арга хэмжээний хувилбар, санал гаргана;

3.6.8. Шаардагдах нөөц, хүч хэрэгслийг татан оролцуулах шийдвэр гаргах;

3.6.9. “Эрэн хайх ажиллагаа ОББС 0001:2018” стандартад заасны дагуу Үндэсний аврах бригадын салбар, 2 хүртэлх бүсийн төвийн Онцгой байдлын хүч хэрэгслийг дайчлан гаргаж, удирдлага зохицуулалтаар хангах

3.6.10. Эрэн хайх, аврах ажиллагаанд нисдэг тэрэг оролцуулах хүсэлт ирүүлсэн тохиолдолд ажиллагааны бүсийн цаг агаар, газар орны нөхцөл, үр дүнг тооцож, ажиллагаанд нисдэг тэрэг ажиллуулах шийдвэр гаргах, онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулах;

3.6.11. Ажиллагаанд оролцуулж буй нисдэг тэргийг ажиллагааны турш шууд удирдлагаар хангах;

3.6.12. Шаардлагатай тохиолдолд Улсын онцгой комиссын Шуурхай штаб байгуулж ажиллуулах саналыг Улсын онцгой комиссын ажлын албанд хүргүүлнэ;

3.6.13. Шуурхай ажиллагааны хөдөлгөөнт удирдлагын байрны бэлэн байдлыг хангуулж ажиллагаанд оролцуулах.

3.7. Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.7.1. Томоохон хэмжээний объектын болон ой хээрийн түймэр, Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвөөс мэдээлэл авмагц зохион байгуулалтын нэгжийн дарга нэгжийн бие бүрэлдэхүүнийг “Яаралтай цуглар” дохиогоор цуглуулж бэлэн байдлыг хангуулж, үүрэг чиглэл өгнө;

3.7.2. Бүс, орон нутгийн нөөц боломжоос давсан объектын болон ой хээрийн гал түймрийн үед удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.7.3. Улсын онц чухал болон галын аюултай, тэсэрч дэлбэрэх объект, онцгой төвөгшилтэй барилга байгууламжид гарсан гал түймэр болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед голомтод Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн удирдах албан тушаалтан, хариуцсан мэргэжилтнийг томилж ажиллуулах;

3.7.4. Гал түймрийн голомтод Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга ирж, удирдлагыг авсан, өгснийг мэдэгдсэнээр унтраах удирдагчийн үүрэг шилжсэнд тооцох;

3.7.5. Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 24 дүгээр тушаалаар баталсан “Гал түймэр унтраах дүрэм” [11]-ийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих;

3.7.6. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед Онцгой

байдлын байгууллагын нисдэг тэргийг шуурхай бүлэг хүргэх, тандалтын нислэг үйлдэх талаар Онцгой байдлын ерөнхий газрын даргад уламжилж, шийдвэрлүүлэх;

3.7.7. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд Зэвсэгт хүчний нисдэг тэргийг дайчлах тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын даргаар уламжлуулан санал, хүсэлтийг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.7.8. Гал түймэр унтраах ажиллагаанд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, аж ахуй нэгжийн шаардлагатай хүч хэрэгслийг татан оролцуулах.

3.7.9. Томоохон хэмжээний гал түймэр унтраах ажиллагаанд УБТЗХНН-ийн Цэрэгжүүлсэн Онцгой байдлын албаны ус тээвэрлэх, шахах зориулалт бүхий вагоныг татан оролцуулах асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

3.8. Холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.8.1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвөөс “Яаралтай цуглар” дохио хүргэсэн үед нэгжийн дарга ажлын байран дээр ирж нэгжийн бие бүрэлдэхүүнийг цуглуулж бэлэн байдлыг хангуулна;

3.8.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлыг үнэлэн гамшгийн голомтод холбоо зохион байгуулах төлөвлөлтийг боловсруулах, холбооны хүч хэрэгслийг тодотгох, дайчлах, хуваарилах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулна;

3.8.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/232 дугаар тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам” [12]-ын дагуу гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод холбооны тасралтгүй найдвартай байдлыг хангах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах;

3.8.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед холбоо, зарлан мэдээлэл, мэдээллийн технологийн бүхий л төрлийн сувгийг ашиглах, тусгай хэрэглээний сүлжээгээр удирдлагын болон харилцан ажиллагааны холбоог зохион байгуулах, хянаж удирдах;

3.8.5. Шуурхай ажиллагааны үед ослын голомтод ажиллах холбоочинг томилж, шаардлагатай холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, хяналт тавина;

3.8.6. Холбоочинг анги, салбарын байрлалаас гарснаас хойш 2 цаг тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр холбоонд орох, ослын голомтод штаб байгуулагдсан тохиолдолд байнгын бусад тохиолдол тогтоосон цагаар холбоонд ороход хяналт тавина. Энэ тохиолдолд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын радио холбооны суурин зангилаа байнгын хүлээн авалтад байна;

3.8.7. Холбооны хүч хэрэгслийн бэлэн байдал, хүрэлцээ, харилцан ажиллах байгууллагуудын холбооны системийн нөхцөл байдал, үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг дахь холбооны сүлжээний байдал, газар орны онцлог, холбооны системийг дэлгэх хугацаа, гамшиг, аюулт үзэгдлийн нөлөөллийг тооцож, холбоог зохион байгуулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ;

3.8.8. Цагийн байдлын өөрчлөлтийн дагуу холбооны систем (радио, үүрэн, сансрын холбоо болон сүлжээ үүсгэх төхөөрөмжүүд)-ийг богино хугацаанд тогтоогдсон хүрээнд өөрчлөн байгуулж, удирдагдах боломжийг бүрдүүлнэ;

3.8.9. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий

байгууллагуудтай “Онцгой байдлын байгууллагын чиглэлийн төлөвлөгөө”[13]-нд тусгагдсаны дагуу холбоог зохион байгуулна;

3.8.10. Шуурхай ажиллагааны үед “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам”, “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод радио холбоо зохион байгуулах заавар” [14]-т тусгагдсаны дагуу удирдлагын болон бүлгийн холбоог зохион байгуулна;

3.8.11. Агаарын замаар хөдөлгөөн үйлдэж буй нисэх нэгж болон суурин удирдлагын төв хооронд харилцаа холбооны сүлжээ (радио, үүрэн болон сансрын холбоо)-г ашиглаж, мэдээ мэдээллийг тухай бүр солилцоход хяналт тавина;

3.8.12. Ажиллагааны үед 3.1-3.17-д заасан албан тушаалтнууд удирдлагын холбоог хангах зориулалт бүхий радио станцтай байх бөгөөд нөхцөл байдлын мэдээллийг тасралтгүй хүлээн авч, шуурхай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлнэ;

3.8.13. Холбооны хөдөлгөөнт удирдлагын төвийн холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгсэл, сүлжээний бэлэн байдлыг хангуулж, ажиллагаанд оролцуулна;

3.8.14. Ажиллагааны үед холбоо, мэдээллийн технологийн сүлжээ, кибер аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.8.15. Холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгсэл, сүлжээнд доголдол гарсан тохиолдолд шуурхай засварлах, хариу арга хэмжээ авах;

3.8.16. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.9. Улсын нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж:

3.9.1. Гамшиг осол тохиолдсон, Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвөөс яаралтай цуглар дохио хүргэсэн үед нэгжийн дарга ажлын байран дээр ирж бие бүрэлдэхүүнийг цуглуулж бэлэн байдлыг хангуулах;

3.9.2. Улсын нөөцийн анги салбаруудыг бэлэн байдалд шилжүүлж, бие бүрэлдэхүүнийг ажлын байранд дээр нь цуглуулах;

3.9.3. Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, хоол хүнс, хувцас хэрэгсэл, шаардлагатай бараа материалаар хангах ажлыг зохион байгуулах;

3.9.4. Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн нөөцөөс бараа материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам” [15]-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.9.5. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зохицуулалт, дэмжлэгээр хангах, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах;

3.9.6. Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам” [16]-ын дагуу дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилан түгээх ажиллагааг зохицуулах;

3.9.7. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.10. Санхүү, ар талын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.10.1. Гамшиг осол тохиолдсон, Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвөөс

яаралтай цуглар дохио хүргэсэн үед нэгжийн дарга ажлын байран дээр ирж нэгжийн бие бүрэлдэхүүнийг цуглуулж, бэлэн байдлыг хангуулах;

3.10.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шуурхай удирдлага зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах бүх төрлийн хангалтыг зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхэд удирдлагад дэмжлэг үзүүлэх;

3.10.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/392 дугаар тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагын ар тал, хангалтын журам” [17]-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.10.4. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.11. Эрсдэлийн удирдлага, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.11.1. Гамшгийн ослын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, болзошгүй эрсдэлийг үнэлж шаардлагатай зөвлөмж боловсруулан хүргүүлэх;

3.11.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан гамшгийн эрсдэлийн зураг боловсруулах, Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллагааны суурь зургаар хангах;

3.11.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/47 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам” [18]-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.11.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/49 дүгээр тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам” [19]-ын дагуу гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаар эрх бүхий албан тушаалтан хэвлэл мэдээлэл, олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;

3.11.5. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг хэвлэл мэдээлэл, сурталчилгааны бүх төрлийн сувгаар шуурхай түгээх;

3.11.6. Голомтод үүрэг гүйцэтгэж буй алба хаагч, олон нийтэд зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх анхааруулга, заавар, зөвлөмжийг олон нийтэд цаг алдалгүй хүргэх;

3.11.7. Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд хүргэж буй мэдээллийн цар хүрээ нийгэмд хэрхэн хүрч, үйлчилж байгаа талаар судалгаа, мониторинг хийх ташаа мэдээлэл түгээхээс сэргийлэх;

3.12. Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.12.1. Хил орчмын болон хил дамнасан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.12.2. Олон улсын эрэн хайх, аврах баг хүлээн авах үйл ажиллагааг зохицуулалтаар хангаж, ажиллагааны турш дэмжлэг үзүүлж ажиллах;

3.12.3. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.13. Захиргаа, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.13.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргаас гарсан шийдвэрүүдийг

албажуулах, эрх зүйн заавар зөвлөмжөөр хангах;

3.13.2. Үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад эрүүл мэнд, сэтгэлзүйн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.13.3. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.14. Гамшгаас хамгаалах сургалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.14.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

3.14.2. Гамшгийн нөхцөл байдалд тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн түр зааварчилгаа, зөвлөмж боловсруулж, хүргүүлэх;

3.14.3. Ажиллагааны явцад гарсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчил, осол гэмтлийг шуурхай арилгах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

3.14.4. Ажиллагаа дууссаны дараа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгжилтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, сургалтын агуулгад тусгах саналыг боловсруулах;

3.14.5. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.15. Хяналт шинжилгээ үнэлгээний асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж

3.15.1. Гамшгийн үеийн хэрэгжүүлж буй арга хэмжээний явцыг хянах, дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах;

3.15.2. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

3.16. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч

3.16.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллийг “Мэдээлэл шуурхай удирдлагын төв” болон “Бүсийн төв”, анги, салбар нэгжээс хүлээн авах;

3.16.2. Голомтод эхний дуудлага, мэдээллээр очсон томилгоот ээлжийн бүрэлдэхүүнээс үүссэн нөхцөл байдлыг тодорхойлж, бодит мэдээлэл авах, нөхцөл байдлыг үнэлэх;

3.16.3. Үүссэн нөхцөл байдлын талаар “Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Ахлах зохицуулагч”, “Бүсийн төвийн Шуурхай удирдлагын зохицуулагч”, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нараас тодотгох;

3.16.4. Шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, үүссэн нөхцөл байдлын мэдээллийг шат дараалан тасралтгүй, шуурхай дамжуулах;

3.16.5. Тасаг, бүлэгт холбоочин томилох, тасралтгүй холбоо зохион байгуулах үүрэг чиглэл өгөх, хяналт тавих;

3.16.6. Ажиллагаанд оролцож буй бүрэлдэхүүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах үүрэг чиглэл, зааварчилгаа өгөх;

3.16.7. Дуудлагаар томилгоот ээлжийн бүрэлдэхүүнийг гаргах;

3.16.8. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн даргад шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, үүрэг чиглэлээр хангах, онцгой байдлын байгууллагын

салбар нэгж, төв, орон нутгийн Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг тодотгох;

3.16.9. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрлөөс хамаарч Ажиллагааны удирдлага, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн удирдлагад мэдээлэл өгөх, удирдлагаас өгсөн үүргийг шуурхай дамжуулах;

3.16.10. Хүч нэмэгдүүлэн ажиллах анги, салбар, бүлгийг гаргах саналыг Ажиллагааны удирдлага болон Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр ангийн захирагчид танилцуулах, шийдвэр гаргуулах;

3.16.11. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, төрөл, цар хүрээг харгалзан, улбар шар, улаан түвшинд шилжсэн үед Ажиллагааны удирдлага, болон Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжид удирдлага, зохицуулалтыг шилжүүлж, удирдлагаас өгсөн үүргийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэх;

3.16.12. Хил орчмын болон хил дамнасан гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”-ын 14 дүгээр хавсралтын дагуу ажиллах;

3.16.13. Томоохон аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай удирдлагын нэгдсэн төв, Засгийн газрын Шуурхай жижүүр, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүл мэндийн байгууллага, Мал эмнэлгийн ерөнхий газар, Одон орон геофизикийн хүрээлэн, Цаг уур, орчны шинжилгээний газартай тогтоосон цагт болон тухай бүр мэдээ мэдээлэл хүлээн авах, дамжуулах, бүх шатны шуурхай штабтай мэдээлэл солилцох, холбооны бэлэн байдлыг хангуулах, шалгах;

3.16.14. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, Ажиллагааны удирдлага болон Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга нарыг мэдээ, мэдээллээр тогтмол хангах;

3.16.15. Ажиллагааны үр дүнг хянах, дүгнэх;

3.16.16. Томоохон аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаарх мэдээлэл, хэрэгжүүлсэн арга хэмжээг “Гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ”-нд бүрэн тусгаж, цахим системд оруулах.

3.17. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага

3.17.1. Орон нутгийн хэмжээнд үүссэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/147 дугаар тушаалаар баталсан “Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”-ыг баримтлан шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах бөгөөд орон нутгийн нөөц боломжоос давсан тохиолдолд хүч хэрэгсэл нэмэлтээр оролцуулах, удирдлагыг дараагийн шатны удирдагчид шилжүүлэх саналыг Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.17.2. Бүс, орон нутгийн хэмжээнд хөдөлгөөнт удирдлагын байрыг “Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”-ын 5 дугаар хавсралтад заасны дагуу тоноглож байнгын бэлэн байдалд байлгах;

3.17.3. Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын дагуу орон нутгийн хэмжээнд хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилан түгээх ажиллагааг зохицуулах;

3.17.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, Ажиллагааны удирдлага, Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн дарга, Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр тогтмол хангах;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ШТАБЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

4.1. Ажиллагааны удирдлагын штаб нь суурин болон хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулагдана.

4.2. Онцгой байдлын ерөнхий газарт төв штаб, газар орон дээр буюу гамшиг, ослын голомтод хөдөлгөөнт штабыг тус тус байгуулж, удирдлагыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр томилно.

4.3. Онцгой байдлын ерөнхий газрын дарга гамшгийн голомтод ажиллаж байгаа тохиолдолд төв штабыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга удирдана.

4.4. Төв штабыг Онцгой байдлын ерөнхий газар дахь Ажиллагааны удирдлагын штабт Улсын онцгой комиссын даргын 2025 оны 5 дугаар тушаалаар баталсан “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”-ын дагуу зохион байгуулна.

4.5. Хөдөлгөөнт удирдлагын байрыг үүссэн нөхцөл байдалд тохируулан голомтын ойролцоо, аюулгүй бүсийг сонгон байгуулж тоноглоно. (автомашин, нисдэг тэрэг, барилга, гэр, майхан гэх мэт)

4.6. Төв штаб нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөдөлгөөнт удирдлагын штабаас ирүүлсэн мэдээллийг боловсруулан Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комисс, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг нөхцөл байдлын мэдээллээр тогтмол хангах;

- Хөдөлгөөнт удирдлагын штабаас ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ажиллагааны хувилбарыг боловсруулан хөдөлгөөнт удирдлагын штабт санал, зөвлөмж хүргүүлэх;

- Хүч хэрэгсэл (хүн хүч, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бүх төрлийн хангалт)-ийн судалгааг гарган хуваарилах, хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах;

- Хөдөлгөөнт удирдлагын болон бусад штабуудыг удирдлага, зохицуулалт, харилцан ажиллагаагаар хангана.

4.7. Хөдөлгөөнт удирдлагын штаб нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гамшиг, ослын голомтод нөхцөл байдлын үнэлж шуурхай шийдвэр гаргах, ажиллагааг шуурхай удирдлагаар хангах,

- Хүч хэрэгслийг бодит нөхцөл байдалд тохируулан оновчтой хуваарилах,

- Тухайн гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллах дүрэм, журам, заавар [20]-ыг баримтлан, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” -ийг мөрдөж ажиллана.

- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг төв штабд шуурхай хүргүүлэх,

- Нэмэлтээр шаардлагатай хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа мэдээллийг гарган төв штабт хүргүүлэх,

4.8. Штаб хоорондын холбоо зохион байгуулалтыг энэ зааврын 3.8 дах хэсэгт заасны дагуу Холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж хариуцан зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

АГААРААС ЭРЭН ХАЙХ АВРАХ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

5.1. Эрэн хайх, аврах ажиллагааны үеэр Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (тэдний эзгүйд тушаалаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан), Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн даргын шийдвэрээр;

5.2. Ой, хээрийн гал түймрийн үед Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (тэдний эзгүйд тушаалаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан), Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн даргын шийдвэрээр тус тус ажиллагаанд нисдэг тэрэг ажиллуулна.

5.3. Ажиллагааны үеэр нисдэг тэрэг хөөрснөөс, буух хүртэлх үйл ажиллагааг Ажиллагааны удирдлага хариуцсан зохион байгуулалтын нэгжийн Агаараас эрэн хайх, аврах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, ой хээрийн түймрийн үед Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжийн Гал унтраах хэлтсийн даргын хамт удирдлага зохицуулалтаар хангана;

5.4. Ой хээрийн түймрийн үед агаараас тандалт хийх нислэгт Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулах;

5.5. Нислэгийн удирдамжийг Ажиллагааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжээс урьдчилан бэлтгэж Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төв, 119 дүгээр анги дээр байршуулсан байна;


5.6. Нисэх бүрэлдэхүүн нисдэг тэрэгний бэлтгэл, бэлэн байдлыг хангах, алба хаагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн зааварчилгааг мөрдүүлж ажиллуулах, нислэгийн үйл ажиллагаанд Улсын нисэхийн тухай хууль, түүнтэй нийцүүлж баталсан эрх зүйн акт, эзэмшиж буй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврыг мөрдөх ажлыг Агаараас эрэн хайх аврах 111 дүгээр анги хариуцан ажиллана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ


ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү зааврыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН БҮДҮҮВЧ



МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ БҮДҮҮВЧ



**ХӨДӨЛГӨӨНТ УДИРДЛАГЫН БАЙРНЫ
ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Зориулалт	Техник, тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Тайлбар
1	Удирдлагын	Ажлын зураг	5	Тухайн газар орны газрын зураг (масштаб)
2		Зургийн ширээ (гэрэлтдэг)	1	Үзэгдэх орчин хязгаарлагдмал үед ашиглах
3		Ухаалаг дэлгэц	1	ОББ-ын цахим мэдээллийн системд ажиллах
4		Цахим хурлын төхөөрөмж, (дэлгэц, спикер, микрофон, веб камер, зөөврийн компьютер)	1	Дээд шатны байгууллагатай шуурхай хурал зохион байгуулах, цаг үеийн мэдээ мэдээлэл хүргэх
5		Таблет	3	Гамшиг, ослын голомтод ашиглах
6		Зургийн аппарат	1	
		Дүрс бичлэгийн камер	1	
7		Тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудас, дугтуй /A4, A5/	20	Шаардлагатай тушаал, шийдвэр гаргах
8		Бичиг хэргийн шүүгээ	1	Гарсан тушаал шийдвэр болон нууцын бичиг баримт хийх
9	Холбоо, мэдээлэл	Радио холбоо /богино, хэт богино долгионы/	5	Гамшиг, ослын голомт, Удирдлагын байртай холбоо зохион байгуулах
10		Дахин дамжуулах станц	1	
11		Суурин үүрэн холбооны утас	1	
12		Сансрын холбооны утас /иридиум/	1	
13		Интернет сүлжээ үүсгэгч /starlink/	1	
14		Сүлжээ салаалагч	1	
15		Утасгүй сүлжээний төхөөрөмж	1	
16		Байршил тогтоогч /GPS/	2	
17		Нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/	1	
18	Зарлан мэдээлэл	Телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авагч	1	
19		Телевиз, радио	1	
20		Чанга яригч	1	
21	Мэдээлэл боловсруулах	Зөөврийн компьютер	3	i5-с дээш үзүүлэлтэй зөөврийн компьютер
22		Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл	2	
23		Хэвлэгч /олон үйлдэлт/	1	3 үйлдэлт болон өнгөт принтер
24		Бичгийн хэрэгсэл /бичгийн цаас, өнгийн бал, харандаа, офицер шугам, өнгийн	3 иж	

		цаас, наалддаг тууз, хайч, үдээсний машин .../		
25	Хөдөлмөр хамгаалал	Хөдөлмөр хамгааллын хувцас /дуулга, бүс, гутал, усны гутал/	8	
26		Тусгай зориулалтын хувцас, хэрэгсэл /хими, цацраг, тэсрэх, халдвар хамгааллын/	Тус бүр 3 иж	
27		Анхны тусламжийн иж бүрдэл	2 иж	Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалттай эм, тариа, ороох боох материал
28		Гал унтраагуур	2	
29	Туслах хэрэгсэл	Майхан	2	3-5 хүний багтаамжтай
30		Зөөврийн цахилгаан үүсгүүр,	2	Цахилгаан тасарсан үед цахилгаан хэрэгсэл ажиллуулах
31		Тог баригч /UPS/	2	Цахилгаан тасарсан үед тоног төхөөрөмжийг цахилгааны хэлбэлзлээс хамгаалах
32		Гадна болон дотор гэрэлтүүлэг	5	Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гадна болон дотор орчныг гэрэлтүүлэх
33		Цахилгааны уртасгагч залгуур (50м дамартай)	2	Нэмэлтээр цахилгаан хэрэгсэл залгах үед ашиглах
34		Олон залгуур	3	
35		Хүчдэл хувиргагч (220В/24В/12В)	1-2	
36		Хүрз, сүх, лоом, хөрөө		
37		Нөөц шатахууны сав (20л)	1	
38		Дугуйны ивүүр, татлага	1	
39		Гар чийдэн	5	Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гадна орчныг гэрэлтүүлэх
40		Эвхэгддэг ширээ, сандал	1 иж	
41		Хөргөгч, ус буцалгагч, богино долгионы зуух, нөөц усны сав, угаалтуур	1	
42		Зөөврийн халаагуур	1	Хүйтэн сэрүүний улиралд хөдөлгөөнт удирдлагын байрыг халаах
43		Гал тогооны хэрэгсэл	1 иж	Гал тогооны хэрэгслээр тоноглогдсон чиргүүл